

# ГЭР БҮЛИЙН УЛАМЖЛАЛТ ЁС



D.Urantsetseg@must.edu.mn



*1.Гэрийн  
эзний  
суудал*

**Зүүн хоймор**

*2.Гэрийн  
эзэгтэйн  
суудал*

**Гал тогооны  
хэрэгслийн  
дээд тал**

*3.Хүүхдийн  
суудал*

**Гэрийн  
баруун  
урд хэсэг**

*4.Зочдын  
суудал*

**Баруун дээд  
хоймор**

# ГЭРТ ЦЭЭРЛЭХ ЁС

01. Цай аягалж байхдаа аяга руугаа амьсгалаа эгц хандуулах, юм ярьж шүлсээ үсэргэхийг цээрлэнэ.

02. Гэрийн хүн зочдын дэргэд тогоо шанага хангинуулах ёсгүй.

1. ГЭРИЙН ЭЗЭГТЭЙ ЦАЙГАА НАР ЗӨВ ЭРГҮҮЛЭГТЭЙ АЯГАЛНА.

**ЗОЧДЫГ ХҮНДЭТГЭХ**

ЗУУХНЫ ГАЛЫГ ХҮЧЭЭР УНТРААЖ БОЛДОГГҮЙ

АРГАЛЫН ДӨРВӨЛЖИЙГ ДҮҮРГЭХ

03. Гэрийн гал голомт болсон зуухыг хүчээр унтраавал тэр айлын удам тасарна гэж үздэг.

04. Хоосон хонуулахыг ихэд цээрлэдэг тул унтахын өмнө заавал дүүргэдэг ёстой.

## ЭХ СУРВАЛЖ “МОНГОЛ АРДЫН УЛАМЖЛАЛТ ЁС, ЗАН ҮЙЛИЙН ДЭЭЖ” 1991ОН

- Айлд орохдоо эхлээд баруун хөлөөр босго алхаж ороод, айлын эзэн суудал зааж өгтөл нь түр зогсоод заасан суудалд нь сууна.
- Айлд ороод, энгэр ташааныхаа товчоор оролддоггүй. Тэгвэл тэнд байгаа аль нэг эмэгтэйд санаархсан болдог.
- Үдээс хойш ирсэн хүн малгайгаа авч тавьбал тэндийд хоноё гэсэн санааны илэрхийлэл юм байна.
- Гэрлээд гарсан хүү, охин нь аав ээжийндээ зочилж ирэхдээ ирэнгүүт шүтээнд нь мөргөж, явахдаа бас мөргөөд ухарч гардаг ёстой. Энэ бол удам угсаагаа хүндэтгэсэн хэрэг.



- Монголчууд гэртээ өөр өөрийн аягатай, явуулын хүн аягаа авч явдаг, тэр хүний аягнанд нь цай, хоол хийж өгдөг ёс байжээ.
- Монголчууд гэрт чанга, хашгирч ярилцах, ялангуяа хоол, ундны үед ярьж шуугилддаггүй ёстой байв.
- Хол ойрын том хүмүүс цуглаад ярилцаж байхад хүүхдүүдийг гадагш гаргадаг, томчуудын ярианд хүүхэд оролцдоггүй.
- Цай буцлаад уудалж байхад, хонины гэдэс чанаж байхад хүн ирвэл их аз, билэг дэмбэрэлтэйд тооцдог. Ер нь айлд орсон хүн болсон идээнээс амсч, явдаг ёстой.
- Айл гэрийн зуухны дэргэд байдаг аргал түлээний авдрыг тэр айлын “галын сан” гэж үздэг учраас түүн дээр сандайж суух, хог хийхийг цээрлэдэг ёстой.

- Айл гэрийн унь, баганаас хоёр гараар атгаж, зүүгдэж барьдаггүй, бурхан шүтээний өмнүүр гардаггүй нь тэр айлын тусгаар байдлыг хүндэтгэсэн ёс юм.
- Айлд орохдоо энгэрээ товчилж, ханцуйгаа буулгаж орно.
- Мөн буу, саадаг, ташуур барьж ордоггүй, харин хутгаа бүснээсээ авч унжуулж ордог.
- Айлд орсон, 18 нас хүрээгүй хүн тоононы голоос дээш суудаггүй. Эр хүн баруун талд, эм хүн зүүн талд, олуулаа орвол насны эрэмбээр суух ёстой.
- Орыг эзэнгүй хонуулдаггүй, эзэнгүй хоноход хүрвэл орон дээрээ сүх, хайч, нүдүүр тавьдаг нь орон гэрийн заяа хаяхаас болгоомжилсон ёсон ажээ.
- Айл, үйл оёж байхад эмэгтэй хүн орвол хамжилцаж заавал нэг учиг дуусгадаг.

# ГЭРТ СУУХ СУУДЛЫН ХЭЛБЭР





# МОНГОЛ ХОСЫН ХУРИМЛАХ ӨСОН

<https://www.youtube.com/watch?v=g6Fnay64M0A>

**1** Бэр болон  
хүргэн  
шинжих өс

**2** Бэрийг  
үдэх болон  
авчрах  
өслол

**3** Хуримлах  
өслол

**4** Сүйн  
бэлэг

**5** Хуримын  
ерөөл

**6** Зочны  
ерөөл

## ДАСГАЛ 2

## Сурах бичиг-133 хуудас

1. Сургаал үгийн утгыг өөрийн үзэл бодлоор тайлбарлаарай.

**Монгол айлын дөрвөн чухал ёс:**

Эцэг эх асралтай

Дүү бишрэлтэй

Эх энэрэлтэй

Хүү тахимдуу

2. Танай гэр бүлийн гишүүд бие биеэ хэрхэн хүндэтгэдэг вэ?

Хүснэгт 48

№	Гэр бүлийн гишүүн	Хүндэтгэл
1	Аав	
2	Ээж	
3	Өвөө, эмээ	
4	Ах, эгч	
5	Дүү	

3. Чиний бодлоор, эцэг эх ямар, ямар үүрэг хариуцлагатай байх ёстой вэ?
3. Аав, ээж, эмээ, өвөө чинь чамд юу гэж сургадаг вэ?
4. Танай гэр бүлд эрхэмлэн дээдэлдэг болон цээрлэдэг ямар ямар ёс байдаг вэ? Түүний цаад утгыг нь чи юу гэж ойлгодог вэ?